

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкны “Б” байрны цонхнуудыг шинэчлэх

Тендер шалгаруулалтын дугаар: Б -2017/3

Монголбанк эрх бүхий тендерт оролцогчоос Монголбанкны “Б” байрны цонхнуудыг шинэчлэх ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: 50,000,000 төгрөгөөс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 50,000,000 төгрөгөөс багагүй байна.

Санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2015, 2016 он

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 14 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 14 цаг 40 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,
Монголбанкны “Өргөтгөл” байрны 2 дугаар давхар, 37 тоот өрөө,
Утас: (976-11) 311039, факс: (976-11) 311471